

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Нэг. Төслийн зорилго:	1.1 Хатанбулаг сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах
Хоёр. Төсөлд тавигдах шаардлага:	2.1. Төслийг хэрэгжүүлэх санхүү, хөрөнгийн баталгаа. Хэрэгжүүлэх төслийн үнийн дүнгийн 85-аас доошгүй хувийг хангасан байна. 2.2. Мэргэжлийн ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй байх; 2.3. Төсөл нь зарласан нөхцөл шаардлага, стандартыг хангасан байх 2.4. Төслөө зарласан хугацаанд ирүүлсэн байх 2.5. Шаардлагатай тохиолдолд холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байх /Гаалийн хяналтын талбай, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх/ 2.6. Газрын үнийг төлөх
Гурав. Төсөл сонгон шалгаруулалтанд оролцох зардал	3.1 Төсөл сонгон шалгаруулахтай холбогдон гарах зардлыг оролцогч өөрөө хариуцна.
Дөрөв. Төслийн иж бүрдэл	4.1. Төслийн иж бүрдэлд: 4.1.1. Төсөл, холбогдох бүх тооцоо, зураглалын хамт 4.1.2. Төслийг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа / Санхүүгийн тайлан, бэлэн мөнгөтэй бол банкны байгууллагын тодорхойлолт, баталгаа, зээлийн эх үүсвэрээр бүрдүүлэх бол зээлийн барьцаанд тавих үл хөдлөх эд хөрөнгийн нотариатчаар гэрчлүүлсэн гэрчилгээний хуулбар, тухайн хөрөнгийн анхны үнэ, үүрэг ноогдуулалт бий эсэх тухай эрхийн улсын бүртгэгчийн лавлагаа, зээл олгохыг зөвшөөрч буй банкны баталгаа, мөн татварын болон нийгмийн даатгалын өргүй байна. / 4.1.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 4.1.4. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмших, ашиглах газарт барих барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн эх загвар /эскиз/ зураг 4.1.5 Барилга байгууламжийн инженерийн хангамжийн ерөнхий шийдлийг тодорхойлсон байх 4.1.5 Төслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө график 4.1.6. Тухайн үйлчилгээ нь байгаль орчин болон хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл, үйлчилгээний явцад учирч болох бусад хор уршгаас хэрхэн урьдчилан сэргийлэх тухай танилцуулга

4.1.7. Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх ач холбогдол, үр ашгийн талаарх тооцоолол

Тав. Төслийг үнэлэх, шалгаруулах

5.1 Ирүүлсэн төслүүдийг төсөл сонгон шалгаруулах тухайн өдөр сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс нь дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлж шалгаруулна. Үүнд:

5.1.1. Төсөл нь зард тусгасан шаардлага болон бүрдлийг хангасан эсэх;

5.1.2. Барилга, хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагад нийцсэн эсэх;

5.1.3. Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулсан эсэх;

5.1.4. Төсөл нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулагдсан бизнес төлөвлөгөөтэй эсэх;

5.1.5. Төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны тоо, хэмжээ;

5.1.6. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой эсэх;

5.1.7. Улс, орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ;

5.1.8. Тухайн газарт явуулах үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.

5.1.9. Шалгуур үзүүлэлтийг ойролцоо буюу адил хангасан нөхцөлд тухайн газарт явуулах үйл ажиллагаа, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх ач холбогдол, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэргийг харьцуулан үзэж шалгаруулна.

5.1.10. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байх

5.1.11. Өөрсдийн санаачлагаар орон нутгийн хөгжилд нэмэр болохуйц ажил, үйлчилгээний санал

Зургаа. Төслийн саналыг ирүүлэх ба баталгаажуулалт

6.1 Төслийн иж бүрдлийг давхар дугтуйнд хийж тамгалж ирүүлнэ.

6.2 Оролцогч нь төслийн эх хувь болон хуулбар хувийг ЭХ ХУВЬ, ХУУЛБАР ХУВЬ гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд хийж ирүүлнэ.

6.3 Гадна дугтуйн дээр Дорноговь аймгийн ГХБХБГазарт гэж хаяглан, 2023 оны 12 дугаар сарын 28 -ний өдрийн 11 цагаас ӨМНӨ НЭЭЖ ҮЛ БОЛНО гэж тэмдэглэсэн байна.

6.4 Доторхи дугтуйн дээр санал ирүүлж буй байгууллагын нэр хаяг байна.

6.5 Төслийн саналыг хүлээж авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлсэн саналыг дугтуй дээр нь ХОЦОРСОН гэж бичээд задлалгүй буцаана.

6.6 Хэрэв саналыг заасны дагуу дугтуйлж ирүүлээгүй тохиолдолд аймгийн ГХБХБГазар хариуцлага хүлээхгүй.

Долоо. Төслийн саналыг хүлээж авах хугацаа

7.1. Төслийг 2023 оны 12-р сарын 27-ны өдрийн 17.00 цагаас өмнө аймгийн ГХБХБГазарт ирүүлнэ.

7.2. Оролцогч саналыг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө бичгээр мэдэгдэл өгч өөрийн саналыг буцаан авах эрхтэй./ Төсөл сонгон шалгаруулалтын урилгын үнийг буцаан олгохгүй. /